Уур Амьсгалын Ногоон Сан /УАНС ЕСБХБ-ны Ногоон эдийн засгийг санхүүжүүлэх бүсийн хөтөлбөр (НЭЗСХ) – Монгол Улс – ХААН Банк I

Байршил:	Монгол Улс
Төслийн дугаар:	53635
Бизнесийн салбар:	Санхүүгийн байгууллагууд
Мэдэгдлийн төрөл:	Хувийн
Байгаль орчны ангилал:	Санхүүгийн байгууллагууд
Хэлэлцэх хурлын огноо:	2022 оны 9-р сарын 7
Төлөв байдал:	Судалгааны шатанд

Англи хэл дээрх ТХББ-ийг нийтэд ил болгосон өдөр: 2022 оны 8-р сарын 9

Төслийн танилцуулга

ХААН Банк ХХК-д 5 жилийн хугацаатай 60 сая ам.долларын тэргүүн ээлжид төлөгдөх нөхцөлтэй зээл олгох төсөл. Санхүүжилтийн багцын хүрээнд ЕСБХБ-аас 45 сая ам.доллар, ЕСБХБ-ны Ногоон эдийн засгийг санхүүжүүлэх бүсийн хөтөлбөр (НЭЗСХ)-ийн Уур Амьсгалын Ногоон Сан /УАНС–гаас 15 сая ам.долларын эх үүсвэрийг бүрдүүлж олгоно.

Төслийн зорилго

Зээл нь ЕСБХБ-ны НЭЗС хөтөлбөрийн УАН сангийн стандарт ба тайлагналын шалгуурт нийцсэн уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох технологи ба үйлчилгээг санхүүжүүлэхэд зарцуулагдана.

Шилжилтийн нөлөөлөл

Шилжилтийн нөлөөлөл 65

Төсөл нь ЕСБХБ-ны Ногоон эдийн засгийг санхүүжүүлэх бүсийн хөтөлбөрийн (НЭЗСХ) Уур Амьсгалын Ногоон Сан /УАНС-ийн **Ногоон шилжилтийн** чадварыг

дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулна. Төслийн санхүүжилт нь бүхэлдээ Монголын НЭЗС хөтөлбөрийн УАНС-ийн Бодлого баримт бичгийн дагуу Ногоон Эдийн Засгийн Шилжилт (GET)-ийн үйл ажиллагаанд зориулагдана. НЭЗС хөтөлбөрийн зээл нь байгаль орчны технологи, ялангуяа сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашигт байдал болон уур амьсгалын тэсвэртэй технологиудыг зах зээлд хурдацтай нэвтрүүлснээр Монгол Улс дахь ногоон эдийн засгийг дэмжинэ.

Зээлдэгчийн талаарх мэдээлэл

ХААН Банк ХХК
ХААН Банк нь 4.7 тэрбум ам.долларын нийт хөрөнгө бүхий Монголын хамгийн том арилжааны банк, 2021 оны эцсийн байдлаар 2.5 тэрбум ам.долларын зээлийн багц, 0.45 тэрбум ам.долларын өөрийн хөрөнгөтэй байна. Тус Банк нь "Мүүдиз" олон улсын үнэлгээний байгууллагаас "B3", Фитч үнэлгээний компаниас "B" зээлжих зэрэглэлтэй бөгөөд төлөвийг тогтвортой гэж тодорхойлсон. ХААН Банк нь дэлхий дахинд чиглэсэн, нийт 547 салбар нэгжээр дамжуулан Монгол орон даяар үйл ажиллагаа явуулж байна.

ЕСБХБ-ны санхүүжилтийн тойм

45,000,000.00 ам.доллар
45 сая ам.долларын тэргүүн ээлжинд төлөгдөх зээлийн санхүүжилт

Төслийн нийт өртөг

60,000,000.00 ам.доллар
60 сая ам.доллар, үүнээс 45 сая ам.доллар нь ЕСБХБ-аас, 15 сая ам.доллар нь Уур Амьсгалын Ногоон Сан /УАНС-аас олгогдоно.

Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны хураангуй

СБ ангилал (2019 БОНБ). ХААН Банк нь ЕСБХБ-ны харилцагч байгууллага бөгөөд Байгаль орчин, нийгмийн бодлого, Нийгмийн журмуудыг нэвтрүүлж Гүйцэтгэлийн шаардлагуудын 2,4 ба 9-р заалтуудыг хангасан байна. ХААН Банк нь цаашид Компанийн зээл, ЖДҮ ба бичил зээл, Худалдааг Дэмжих Хөтөлбөрийн Байгаль орчин нийгмийн журмуудыг дагаж мөрдөн Гүйцэтгэлийн шаардлагуудын 2,4 ба 9-р заалтуудыг хангаж, ЕСБХБ-ны санхүүжилтийн багцаар санхүүжих ХААН Банкны бүх зээлдэгч, дэд зээлдэгч нар байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон хөдөлмөр эрхлэлтийн дотоодын шаардлагуудыг хангах шаардлагатай. ХААН Банк нь Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны жилийн тайланг ЕСБХБ-нд гаргана.

НЭЗС хөтөлбөрийн ХААН Банкны зээлдэгчид НЭЗС хөтөлбөрийн Бодлогын баримт бичигт тусгасны дагуу Эрчим хүчний үр ашиг, Нөөцийн үр ашиг, Сэргээгдэх эрчим хүчний шалгууруудыг хангах шаардлагатай. Сэргээгдэх эрчим хүчний технологийн санхүүжилт Сэргээгдэх эрчим хүчний Удирдлагын аргыг дагаж мөрдөнө. Эдгээр шаардлагуудыг ЕСБХБ-ны Зөвлөх тодорхойлох болно.

Техникийн хамтын ажиллагаа

Ногоон эдийн засгийг санхүүжүүлэх бүсийн хөтөлбөрийн (НЭЗСХ) хүрээнд 6 сая еврогийн техникийн туслалцааны багцыг ЕСБХБ-ны Хувьцаа эзэмшигчдийн тусгай сан, Уур Амьсгалын Ногоон Сан (УАНС) ба Япон Улсын санхүүжилтээр бүрдүүлнэ.

Төслийн техникийн хамтын ажиллагааны зорилго нь ХААН Банкнд чадавх бүрдүүлэх, НЭЗСХөтөлбөрийн зээлийн хэрэгжилт ба мониторинг хийхэд дэмжлэг үзүүлэхэд оршино. Төслийн Зөвлөх нь худалдааны үйл ажиллагаан дахь уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох техник технологийн талаар мэдээлэл өгөх, төслийн үнэлгээ хийх, давхар зээлдэгчдэд хамгийн оновчтой технологийн сонголт хийхэд нь туслалцаа үзүүлэх зэрэгт ноу-хау хуваалцаж ажиллана. Монголын НЭЗСХөтөлбөрийн техникийн туслалцааны багцад тус хөтөлбөрт оролцогч санхүүгийн байгууллагуудад тусгайлан оноогдсон техникийн туслалцааны хуваарилалт хийгдээгүй. Мөн ногоон зээлийн бүтээгдэхүүний маркетинг ба загварчлалын жендерийн онцлогтой эрэлт, хэрэгцээний асуудлуудыг шийдэх тусгай жендерийн техникийн туслалцаа нэг зэрэг хэрэгжинэ ("НЭЗС хөтөлбөрийн Жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөний Хэрэгжилт ба Мониторинг").

Харилцагчийн оруулах хувь нэмэр: ХААН Банк нь төслийн хэрэгжилттэй холбогдолтой маркетинг ба сургалтын зардалд 10,000 еврогоос доошгүй дүнгээр хувь нэмэр оруулна.

Нэмэлт ашиг тус

Дотоодын зах зээл дээр дутагдаж буй дунд хугацааны зээлийн санхүүжилт ба техникийн туслалцааг хосолсон. Жендерийн тэгш эрхийн талаар мэдээлэл олгох арга хэмжээ зохион байгуулах, ХААН Банкны ажилтнуудад сургалт хийж зээл олголтын явц дахь жендерийн асуудлыг тусгаж жендерийн тэгш эрхийг хангах болно.

Компанийн холбоо барих мэдээлэл

Б.Эрдэнэдэлгэр, ХААН Банкны Хөрөнгө зохицуулалтын газрын захирал
И-мэйл: erdenedelger.b@khanbank.com
Утас: +976 11 332 333, 976 70 117 023
Вэб хуудас: https://www.khanbank.com
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сөүлийн гудамж-25, Шуудангийн хайрцаг - 192

Шилжилтийг ойлгох нь

Шилжилтийн нөлөөллийг хэмжих чиглэлд ЕСБХБ-ны баримталдаг арга хандлагын талаарх нэмэлт мэдээллийг эндээс авна уу.

Бизнес боломжууд

Бизнес боломжууд болон худалдан авалтын талаар үйлчлүүлэгч компанитай холбогдоно уу.

ЕСБХБ-тай хамтран ажиллах боломжууд (худалдан авалттай холбоогүй)-ын талаар сонирхвол дараах утасны дугаар, цахим хаягаар холбоо барина уу.

Утас: +44 20 7338 7168
Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээлэл авахыг хүсвэл ЕСБХБ-ны Худалдан авалт хэсэгт зочилно уу.

Утас: +44 20 7338 6794
Цахим шуудан: procurement@ebrd.com

Ерөнхий лавлагаа

Дэлгэрэнгүй лавлагааг ЕСБХБ-ны Лавлагааны маягт ашиглан авах боломжтой.

Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ)

БОНБ болон холбогдох Гүйцэтгэлийн Шаардлагууд (ГШ) нь ЕСБХБ-ны “байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил”-ийг хөхиүлэн дэмжих үүрэг амлалтаа биелүүлэхэд баримтлах арга замуудыг тодорхойлдог. БОНБ болон ГШ-д үйлчлүүлэгчийн зүгээс олон нийтийн мэдээлэл, хэлэлцүүлгийн талаарх үндэсний хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг дагаж мөрдөх , мөн оролцогч талуудын санал гомдол, ялангуяа үйлчлүүлэгч ба төслийн байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн талаарх санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг гомдол барагдуулах механизм бий болгох тухай тодорхой заалтууд багтсан байдаг. ЕСБХБ нь аливаа төслийн байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн мөн чанар, цар хүрээнд дүйцүүлэн, тухайн төслийн улмаас үүсэх эрсдэл, үр нөлөөллийн тухай мэдээллийг шаардлагын дагуу ил болгох, эсвэл оролцогч талуудтай утга учиртай зөвлөлдөх, тэдний санал хүсэлтийг харгалзан үзэж, хариу өгөх нэмэлт шаардлагыг үйлчлүүлэгчиддээ тавьдаг.

Энэ чиглэлд ЕСБХБ-ны хэрэгжүүлдэг практикийн талаарх нэмэлт мэдээллийг БОНБ-д оруулсан болно.

Бүрэн төгс байдал ба комплаенс

ЕСБХБ-ны Комплаенс хариуцсан Захирлын Ажлын алба (КЗАА) нь сайн засаглалыг хөхиүлэн дэмжиж, олон улсын шилдэг практикт нийцүүлэн Банкны бүхий л үйл

ажиллагаан дахь бүрэн төгс байдлыг хамгийн дээд стандартаар хангахад анхаарч ажилладаг. Төслүүдийн зүгээс Банкинд бүрэн төгс байдал, нэр хүндийн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй эрсдэл үүсгэхгүй байх нөхцлийг хангахын тулд тус Банк бүх үйлчлүүлэгчийнхээ бүрэн төгс байдалд нарийвчилсан үнэлгээ хийдэг. Банк аливаа асуудлыг төслийн үнэлгээг батлах үе шатанд илрүүлэн тогтоож, шийдвэрлэх нь Банкны транзакцийн бүрэн төгс байдлыг хангах хамгийн үр дүнтэй арга зам гэж үзэж байна. КЗАА нь эдгээр хамгаалалтын арга хэмжээг авахад голлох үүрэг гүйцэтгэж, мөн төслүүдийн хөрөнгө оруулалтын дараах бүрэн төгс байдлын эрсдлийг хянахад тус дөхөм үзүүлдэг.

Түүнчлэн, КЗАА нь ЕСБХБ-ны санхүүжүүлсэн төслүүдтэй холбоотой залилан мэхлэлт, авилга, хээл хахууль болон буруу үйлдлийн талаарх гомдлын мөрөөр судлан шалгах үүрэгтэй. Банкны ажилтнууд, эсвэл гадна байгаа хэн ч бай залилан мэхлэлт болон авилгал үйлдэгдсэн хэмээн сэжиглэж буй тохиолдолд Комплаенс хариуцсан захиралд compliance@ebrd.com цахим шуудангийн хаяг руу бичгээр илтгэх ёстой. Мэдээлэгдсэн бүхий л асуудлын мөрөөр хянан шийдвэрлэх ажлыг КЗАА гүйцэтгэнэ. Нэр хаягтай болон нэр хаяггүй бүх мэдээллийг шалгана. Мэдээллийг Банкны албан ёсны хэл болон үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын хэлний алинаар ч үйлдэж болно. Ирүүлсэн мэдээлэл нь чин сэтгэлийн байх ёстой.

Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)

МХБ нь 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш ЕСБХБ мэдээллийг хэрхэн олон нийтэд ил тод болгох, өөрийн стратеги, бодлого болон үйл ажиллагааны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэн сурталчлах чиглэлд оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөх арга замуудыг тодорхойлсон байдаг. ЕСБХБ-ны вэб сайтаас ямар мэдээлэл авах боломжтойг мэдье гэвэл Мэдээллийн хүртээмжийн бодлого хуудсанд зочилно уу.

Мэдээлэл авах тодорхой хүсэлтээ ЕСБХБ-ны Лавлагааны маягт ашиглан илгээх боломжтой.

Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)

Хэрэв байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбоотой санал гомдлоо үйлчлүүлэгч болон Банкинд тавьж шийдвэрлүүлэх (жишээлбэл: үйлчлүүлэгчийн Төслийн түвшний гомдол барагдуулах механизмаар дамжуулж, эсвэл Банкны удирдлагатай шууд харилцах замаар) оролдлого, хүчин чармайлт нь амжилтгүй болвол, хувь хүн болон байгууллагууд санал гомдлоо ЕСБХБ-ны Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)-аар дамжуулан шийдвэрлүүлэхийг зорьж болно.

ТХХБМ нь Төсөлтэй холбоотой бусдад хор хохирол учруулсан (эсвэл учруулж болзошгүй) гэж үзэж буй асуудлуудыг хараат бусаар хянан шалгадаг. Энэхүү Механизмын зорилго нь байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбогдох асуудлуудыг шийдвэрлэх талаар Төслийн оролцогч талуудын хоорондох яриа хэлэлцээг дэмжих; Банк өөрийн Байгаль орчин, нийгмийн бодлого, эсвэл Мэдээллийн хүртээмжийн бодлого–ын Төсөлд холбогдох заалтуудыг дагаж мөрдсөн эсэхийг тогтоох; мөн шаардлагатай тохиолдолд Банкны зүгээс эдгээр бодлогод үл нийцсэн зөрчлийг арилгах, түүний зэрэгцээ цаашид тийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

ТХХБМ болон түүний эрх үүргийн талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл Төслийн хариуцлагын хараат бус механизмын вэб сайт, хянан шалгуулах хүсэлт тавих бол Хүсэлт хаягаар тус тус хандана уу. Эсвэл ТХХБМ-ын талаар, мөн санал хүсэлт хэрхэн тавих тухай чиглэл заавар, нэмэлт мэдээлэл авах бол ipam@ebrd.com цахим шуудангаар хандаж болно.